



# ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА

“ЭМ ЖИ ЭЛ АКУА”

Үндсэн андеррайтер

“Инвескор Капитал  
ҮЦК” ХХК



Туслах андеррайтер

“Таван Богд Капитал  
ҮЦК” ХХК



Аудитын компани

“Пи Кэй Эф Монголиа  
Аудит” ХХК



Үнэлгээний компани

“Итгэлт-Эстимэйт”  
ХХК



Хуулийн зөвлөх

“Өмгөөллийн Сноу Хилл  
Консалтанси” ХХН



## Андреррайтер



## “Инвескор Капитал ҮЦК” ХХК

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, 13-р хороолол, Парисын гудамж 42, Ай Си Ти Тауэр барилга, 15 давхар, 1503 тоот  
Утас: (976) 7755 0077  
И-мэйл: info@icapital.mn  
Вэб хуудас: www.icapital.mn

## Туслах андеррайтер



## “Таван Богд Капитал ҮЦК” ХХК

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай-16, Галлериа Улаанбаатар худалдааны төв, 1 давхар  
Утас: (976) 7272 7282  
И-мэйл: cr@tavanbogdcapital.com  
Вэб хуудас: tavanbogdcapital.com

## Аудитын компани



## “Пи Кэй Эф Монголиа Аудит” ХХК

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамъяан гүний гудамж-18/1, Даун Таун Оффис, 602 тоот  
Утас: (976) 7505 7979  
И-мэйл: info@pkf.mn  
Вэб хуудас: www.pfk-ifs.mn

## Үнэлгээний компани



## “Итгэлт-Эстимэйт” ХХК

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Хүннү, Олимп плаза, 401 тоот  
Утас: (976) 7600 5638  
И-мэйл: itgelt\_estimate@itgeltgroup.mn  
Вэб хуудас: www.itgeltgroup.mn

## Хуулийн зөвлөх



## “Өмгөөллийн Сноу Хилл Консалтанси” ХХН

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Гэндэнгийн гудамж 16, Ардчиллын өргөө, 6-р давхар  
Утас: (976) 7711 8193  
И-мэйл: info@snowhill.mn  
Вэб хуудас: www.snowhill.mn

# Агуулга

## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

### ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

<b>1</b>	<b>ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ</b>	<b>7</b>
	1.1. Компанийн танилцуулга	8
	1.2. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц	11
	1.3. Компанийн үүсэл хөгжил	12
	1.4. Үйл ажиллагаа ба онцлог	13
	1.5. Санхүүгийн үзүүлэлт, төсөөлөл	19
	1.6. Төлөөлөн Удирдах Зөвлөл	23
	1.7. Удирдлагын баг	25
	1.8. Үнэт цаас гаргагчийн тусгай зөвшөөрөл, оюуны өмчийн эрх	27
	1.9. Байгаль орчин, нийгэм, засаглалын тогтвортой хөгжлийн бодлого	28
<b>2</b>	<b>ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗАХ ЗЭЭЛ БА СТРАТЕГИ</b>	<b>29</b>
	2.1. Олон улсын савласан цэвэр усны зах зээл	30
	2.2. Монгол Улсын савласан цэвэр усны зах зээл	33
	2.3. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны төлөвлөгөө	36
	2.4. Эрсдэлийн хүчин зүйлс ба удирдлага	39
<b>3</b>	<b>ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ</b>	<b>40</b>
	3.1. Үнэ тогтоосон үндэслэл	41
	3.2. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт	42
	3.3. Хувьцааны онцлог	43
	3.4. Үнэт цаас худалдан авах захиалга өгөх заавар	44
	3.5. Үнэт цаастай холбоотой эрсдэлийн хүчин зүйлс	45
	<b>ХАВСРАЛТ</b>	<b>46</b>

## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

“Эм Жи Эл Акуа” ХХК (цаашид “Үнэт цаас гаргагч” гэх) нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид “СЗХ” гэх) болон Монголын Хөрөнгийн Бирж (цаашид “МХБ” гэх)-ийн холбогдох журмуудын дагуу компанийн нийт гаргасан хувьцааны 26.73 хувийг нэмж гарган нийтэд санал болгож байна.

Үнэт цаас гаргагч болон Үндсэн андеррайтер болох “Инвескор Капитал ҮЦК” ХХК болон Туслах андеррайтер болох “Таван Богд Капитал ҮЦК” ХХК (цаашид хамтад нь “Андеррайтерууд” гэх) нь энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгагдаж хавсаргасан аливаа мэдээллүүдийг үнэн зөв, бүрэн гүйцэд бөгөөд хуурамчаар бүрдүүлээгүй гэдгийг албан ёсоор баталж байна. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь энэ баримт бичигт агуулсан мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд бөгөөд хуурамчаар бүрдүүлсэн, худал төөрөгдүүлсэн аливаа баримт байхгүй гэдгийг албан ёсоор баталж байна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгыг бэлтгэх үеийн байдлаар Төмөрбат овогтой Дөлгөөн Гүйцэтгэх захирлын үүргийг гүйцэтгэж байсан бол 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн Хархүү овогтой Тэгшээ нь Гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байгаа болно. Иймд Та бүхэн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа энэхүү танилцуулга дахь Гүйцэтгэх захирлын мэдээлэлд өөрчлөлт орсныг анхаарна уу. Энэ нь Үнэт цаасны танилцуулгын хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй болохыг мэдэгдэж байна.

Үнэт цаас гаргагчийн хувьцааг СЗХ болон МХБ бүртгэсэн нь уг хувьцаа, үнэт цаасны эрсдэлийн талаар аливаа баталгаа гаргаагүй болохыг анхаарах нь зүйтэй. Энэхүү үнэт цаасыг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч Таны хувьд ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, Үнэт цаасны танилцуулга, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалж үзсэний үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

Хөрөнгө оруулагч Та санхүүгийн, хуулийн, татварын болон бусад зөвлөхүүдээс Үнэт цаас худалдаж авах, эзэмшихээс өмнө мэргэжлийн зөвлөгөө, тусламж авах нь үргэлж зүйтэй байдгийг харгалзана уу.

Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад шаардлагатай лавлах тодруулах зүйлсийг Үнэт цаас гаргагч “Эм Жи Эл Акуа” ХХК, Үндсэн андеррайтер “Инвескор Капитал ҮЦК” ХХК-д хандана уу.

## ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

Үнэт цаас гаргагч	“Эм Жи Эл Акуа” ХХК
Үнэт цаасны төрөл	Энгийн хувьцаа
Үнэт цаасны бүртгэл	Монголын Хөрөнгийн Бирж
Нийт эргэлтэд гаргасан энгийн хувьцааны тоо ширхэг	240,000,000
Нийтэд санал болгох эзэмшлийн хувь	26.73%
Анхдагч зах зээлд санал болгох хувь	174 төгрөг (14.24 хувиар хямдруулсан үнээр тооцов)
Нэмж гаргах хувьцааны тоо ширхэг	87,555,616
Нийтэд санал болгосны дараах хувьцааны тоо ширхэг	327,555,616
Стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>Нэмж гаргах хувьцааны 80 хүртэлх хувь буюу 70,044,492 ширхэг хүртэлх энгийн хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох;</li> <li>Стратегийн хөрөнгө оруулагчид хоёрдогч зах зээл нээгдсэнээс хойш 6 сараас доошгүй хугацаанд хувьцаагаа арилжаанд оруулахгүй байх</li> </ul>
Жижиглэнгийн хөрөнгө оруулагчдад санал болгох нөөц	Үндсэн хэсэг буюу 20 ба түүнээс дээш хувийг хувь тэнцүүлэн хуваарилах нөхцөлөөр
Татан төвлөрүүлэх дүн	15,234,677,184 төгрөг
Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт	Орон нутагт савласан цэвэр усны үйлдвэр нээх төслийн хөрөнгө оруулалт, том савлагаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шугам, трансформатор, эргэлтийн хөрөнгийн дахин санхүүжилт
Хувьцааг арилжаалах арга	Тогтоосон үнийн арга
Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсонд тооцох хувь	100 хувь
Үнэ тогтворжуулах хөтөлбөр	Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 6 сарын хугацаанд анх гаргасан үнээс 15 хувь болон түүнээс дээш хэмжээнд буурсан тохиолдолд 1,000,000,000 (нэг тэрбум) хүртэлх төгрөгийн үнийн дүнгээр хөтөлбөрийг хэрэгжүүлнэ

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Сэр-Од

**Алтантуяа**

ТУЗ-ийн дарга

Эм Жи Эл Акуа” ХХК нь 2001 онд үүсгэн байгуулагдсан 22 жилийн түүхтэй Монгол Улсын хамгийн анхны, цэвэр усны ууган үйлдвэр юм.

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилт, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, зорилгуудтай уялдуулан байгалийн цэнхэр алтыг дэлхийн дэвшилтэт технологи, хүнсний үйлдвэрлэлийн стандартаар, байгальд ээлтэй савлагаагаар үйлдвэрлэн, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Сайн засаглалтай компанийг бүтээхээр зорьж буйн хувьд хамгийн хөнгөн эко саваар бүтээгдэхүүнээ савлаж, үүссэн хог хаягдлыг

зэргэлдээ компанидаа дахин боловсруулах байдлаар хог хаягдлаас хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хувь нэмрээ оруулж байна.

Цаашид компани өөрийн салбар үйлдвэрийг хөгжиж буй улс орнуудад байгуулан үйлдвэрлэлээ өргөжүүлэхээр ажиллаж байна.

Компанийн хэтийн төлөвлөгөөнд хаягдал усыг дахин боловсруулах, усны далан байгуулах болон хүний биед эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх зэрэг бүтээгдэхүүн болон төслүүдийг хөгжүүлэхээр тусгасан.

2024 оны босгон дээр бид олон нийтийн компани болж өөрсдийн бүтээсэн үнэ цэнэ, туршлага, мэдлэгээ Монгол түмэнтэйгээ хуваалцан, сайн засаглал, өндөр технологийг нутагшуулсан Дэлхийн компанийг хамтдаа бүтээхээр хөрөнгө оруулагч та бүхнийг урьж байна.

---

## ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

- ◆ Компанийн танилцуулга
- ◆ Хувьцаа эзэмшигчдийн бүтэц
- ◆ Компанийн үүсэл хөгжил
- ◆ Үйл ажиллагаа ба онцлог
- ◆ Санхүүгийн үзүүлэлт, төсөөлөл
- ◆ Төлөөлөн удирдах зөвлөл
- ◆ Удирдлагын баг
- ◆ Тусгай зөвшөөрөл, оюуны өмчийн эрх
- ◆ Байгаль орчин, нийгэм, засаглалын тогтвортой хөгжлийн бодлого

## ЭМ ЖИ ЭЛ АКУА САВЛАСАН ЦЭВЭР УСНЫ ҮЙЛДВЭРЛЭЛЭЭР ДАГНАСАН ҮНДЭСНИЙ ХАМГИЙН ТОМ КОМПАНИ

Үнэт цаас гаргагч нь савласан цэвэр усны зах зээлд 22 жилийн туршлагатай ууган үйлдвэрүүдийн нэг бөгөөд цэвэр усыг хүртээмжтэй байдлаар хүн бүрд хүргэхийн тулд 22 жилийн туршлага дээрээ суурилан савласан цэвэр усыг боломжит хамгийн бага өртгөөр, чанарын дээд түвшинд үйлдвэрлэдэг. 2022 оны байдлаар Монгол Улсын нийт савласан цэвэр усны үйлдвэрлэлийн 32.1 хувийг дангаар нийлүүлсэн юм. Түүнчлэн Үнэт цаас гаргагч нь 2023 онд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хүчин чадлаа сайжруулснаар Монгол Улсын савласан цэвэр усны хэрэглээг бүрэн хангах хэмжээнд өргөжүүлсэн бөгөөд үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа олон улсын чанарын удирдлагын ISO 9001:2015 болон олон улсын хүнсний аюулгүй байдлын FSSC 22000 стандартууд, Монгол Улсын савласан цэвэр усны болон гүний усны MNS 5007:2007 (MNS 5007:2022), MNS 0900:2016 стандартуудыг нэвтрүүлж, баримтлан ажиллаж байна.


Үнэт цаас гаргагч нь бизнесийн үнэ цэнээ дараах гурван зарчим дээр суурилан бэхжүүлдэг. Үүнд:




**ТОГТВОРТОЙ  
БИЗНЕСИЙН ХӨГЖИЛ**



**ЭКО  
ХЭРЭГЛЭЭ**



**БОЛОМЖИЙН ҮНЭТЭЙ  
БҮТЭЭГДЭХҮҮН**



**ТОГТВОРТОЙ  
БИЗНЕСИЙН ХӨГЖИЛ**

- Захиалгын 100 хувь онлайн систем
- + 60 түгээгч
- + 600 худалдааны төлөөлөгч
- + 5,000 харилцагч



**ЭКО  
ХЭРЭГЛЭЭ**

- Нэмэлт өнгө оруулагчгүй
- Хамгийн энгийн материал хийцлэлтэй
- Савны жин хөнгөн
- Байгальд хурдан шингэх, дахин боловсруулах зардлыг бууруулдаг



**БОЛОМЖИЙН ҮНЭТЭЙ  
БҮТЭЭГДЭХҮҮН**

- + 150 сая литр хүчин чадал
- Найдвартай бэлтгэн нийлүүлэгчид


**TECH-LONG**

**Sidel**

**KRONES**



## АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛС



## ШИНГЭН ХҮНСНИЙ САЛБАРЫН АНХДАГЧ “VOYAGE” БРЭНД ЭХЭЛСЭН ТҮҮХ

Нийслэл хотын хүн ам 1998 оноос огцом нэмэгдэж, орон нутгаас хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн эрчимжсэнээр Улаанбаатар хотын ус хангамжийг сайжруулах төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж эхэлсэн ба 2000 оноос олон улсын усны чанарын стандартууд батлагдан мөрдөгдөж эхэлсэн. Тухайн үед Монгол Улсын нийт хүн амын ердөө 21 хувь нь цэвэр усыг унданд хэрэглэдэг байсан нь дэлхийн дунджаас 3 дахин бага үзүүлэлт байв.

2000-аад оны эхэн үед Монгол Улсын аж үйлдвэрийн салбар уналтад орж, боловсруулах үйлдвэрүүдийг сэргээх, шинээр бүтээн байгуулах ажлууд удааширч, хүн ам нь хүнсний хэрэгцээний дутагдалд орсон хүнд цаг үе байсан. Тухайн үед ОХУ-ын гидрологийн эрдэмтдийн багтай хамтарсан зөвлөгөө, судалгаан дээр үндэслэн Улаанбаатар хотод хамгийн цэнгэг бөгөөд баялаг усны ундарга бүхий байршилд баталгаатай ундны усны хангамжийн эх үүсвэрийг тогтоож, Бумбатын рашаанаас 7 км-ын зайд рашааны судлыг даган цэвэр усны үйлдвэрийн шавыг тавьж байсан түүхтэй.



## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

IPO хийхийн өмнө



IPO хийсний дараа



Ти Эм Эл Трейд компанийн нэгдэл нь шингэн хүнсний сав баглаа боодлын зах зээлд тэргүүлэгч үндэсний компани

100%

IPO хийхийн өмнө



IPO хийсний дараа




73.27%




26.73%

## ТИ ЭМ ЭЛ ТРЕЙД КОМПАНИЙН НЭГДЛИЙН ТУХАЙ



## КОМПАНИЙН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ



# ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ОНЦЛОГ

## Чанарын тасралтгүй сайжруулалт

### FSSC 22000 (Food Safety System Certification)

Хоол хүнсний аюулгүй байдлаас гадна хүнсний чанар, хамгаалалт, хуурамч бүтээгдэхүүнээс сэргийлэх ажиллагааг хамарсан цогц ажиллагааг **ХАНГАСАН**



### ISO 9001:2015 (Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо)

Түүхий эд материалыг хүлээн авахаас эхлэн үйлдвэрлэлийн бүх үе шатыг хянаж, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг ажиллагааг **ХАНГАСАН**

### MNS 5007:2022


Савласан усны үйлдвэрлэх, шалгаж хүлээх авах, савлах, хаяглах, хадгалах, тээвэрлэх шаардлагыг **ХАНГАСАН**



### MNS 0900:2016

Хүн амын үндны болон ахуйн зориулалтаар хэрэглэх усны эрүүл ахуйн болон чанар, аюулгүй байдлын шаардлагыг **ХАНГАСАН**

## Хөндлөнгийн болон дотоод хяналт шинжилгээ



## Дэлхийд тэргүүлэгч олон улсын дэвшилтэт технологи



Франц Улсын “Sidel” брэндийн бүрэн автомат хуруу сав үлээх төхөөрөмж

35.6 САЯ ЛИТР



БНХАУ-ын “Techlong” брэндийн бүрэн автомат савлах, багцлах цогц төхөөрөмж

25.7 САЯ ЛИТР



ХБНГУ-ын “Krones” брэндийн сав үлээх, савлах, багцлах цогц систем

96.6 САЯ ЛИТР



## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СХЕМ




### Гүний усыг нөөцлөх /5 тонн/

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 3-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, хатуувтар ус бөгөөд MNS 0900:2018 стандартын шаардлага хангасан.



### 6 давхар урвуу осмосис шүүлтүүрээр шүүж, озонжуулж халдваргүйжүүлэх

Олборлосон гүний эрдэст усаа цэвэршүүлэн боловсруулахдаа олон улсад өргөн хэрэглэгддэг давс, хүнд металл, илүүдэл эрдэс бодис, нян бактери, вирус болон бусад механик нэгдлүүдийг өндөр түвшинд шүүдэг технологийг ашигладаг.



### Озонжуулах халдваргүйжүүлэх

Озонжуулах аргаар цэвэршүүлсэн усыг халдваргүйжүүлдэг ба тус арга нь усан дотор нян бактери өсөж үржих боломжийг 100хувь устгадаг.

	Озонжуулах	Хлоржуулах	Хэт ягаан туяаны гэрлээр	Нүүрсний шингээгч бодисоор
Шимэгч	✓	✗	✗	✓
Бактери	✓	✗	✓	✗
Вирус	✓	✓	✓	✗

I  
Механик  
Элсэн  
шүүлтүүр

II  
Нүүрсэн  
идэвхжүүлсэн  
шүүлтүүр

III  
Нүүрсэн  
идэвхжүүлсэн  
шүүлтүүр

IV  
Цаасан  
шүүлтүүр

V  
I мембран  
Урвуу  
осмосын  
шүүлтүүр

VI  
II мембран  
Урвуу  
осмосын  
шүүлтүүр

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СХЕМ



### 1.Түүхий эдийг хүлээн авах




### 2.Хуруу сав, бөглөөг ариутгах



Ти Эм Эл компанийн нэгдэл дэх бэлтгэн нийлүүлэгчид чанарын шаардлагад нийцсэн хуруу сав, бөглөө, шошго, багцлагч уут, бариул нийлүүлдэг.

### 3.Хуруу сав, гуурсаар үлээх




### 4.Савыг ариутгах



Хуруу савыг 80-96 хэмийн халуун уур ба озонжуулсан усаар ариутгасны дараа өндөр даралтаар үлээж сав болгодог.

Хагас нэвчүүлэх мембран технологийг ашиглан усыг цэвэршүүлэх үйл явц нь усанд агуулагдаж буй бичил хэсгүүдийн хэмжээнээс хамааран 4 төрлийн аргаар хийгддэг. Эдгээр аргаас Үнэт цаас гаргагч нь хамгийн түгээмэл ашиглагддаг урвуу осмосын аргыг ашигладаг ба олон улсад уг аргыг ус цэвэршүүлэх дэвшилтэт арга гэж үздэг байна. Урвуу осмосын аргаар цэвэршүүлсэн Voyage брэндийн усны онцлог нь гүний усанд агуулагдаж буй эрдэс бодисыг тэнцвэржүүлэн, усны үндсэн бүтцийг алдагдуулахгүйгээр хүний биед шаардагддаг шингэнийг нөхдөг байна.

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СХЕМ





## ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

2023 оны 6 дугаар сарын байдлаар Үнэт цаас гаргагч нь 2 нэр төрлийн болон хэрэглэгчдийн хэрэглээнд тохирсон 6 төрлийн савлагаатай Voyage брэндийн савласан цэвэр усыг нийлүүлж байна.

### Нэг удаагийн амны цангаа тайлах савлагаа



500

Борлуулалтын бүх сувгууд, бүх насны хэрэглэгчдэд зориулсан, амны цангаа тайлах зохимжит үндсэн савлагаа



Ph8.5 500

Байгалийн цэвэршүүлсэн хужраар баяжуулж хүчил шүлтээр тэнцвэржүүлэн зөөлрүүлсэн тул ходоодны хүчин тогтмол ихэсдэг хэрэглэгчдэд зориулсан.



330 мл

Mining, At work, ED, Horeca, CVS сувгийн хэрэглэгчдэд чиглэсэн.



200 мл

Pocket water буюу халаасанд багтахуйц савлагаа. Богино хэмжээний хурал уулзалт, эмийн сан, бага насны хүүхдүүдэд чиглэгдсэн ба цэвэр усны хаягдлыг багасгадаг.

### Том савлагаа



800 мл

Бүх төрлийн спортоор хичээллэх үед хэрэглэхэд тохиромжтой савлагаа.



1.5 литр

RG, Mining, сувгийн хэрэглэгчдэд зориулсан хэмнэлттэй савлагаа.



4.5 литр

Гэр бүлийн хэрэглээнд зориулагдсан хамгийн том савлагаа. Авч явахад хялбар бариултай, баллонтой ус буцалгагчид суурилуулан ашиглах боломжтой ухаалаг бөглөөтэй.

## БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

### Сонголттой бүтээгдэхүүнийг санал болгох

- ◆ 6 төрлийн савлагаа
- ◆ Цэвэр уснаас гадна витаминжуулсан, эрдэсжүүлсэн цэвэр ус
- ◆ Эко савлагаа
- ◆ Оновчтой үнийн бодлого
- ◆ Нэмүү өртгийг бууруулсан түүхий эд
- ◆ Савны хөнгөн жин

### Бүтээгдэхүүнийг зах зээлд таниулах

- ◆ Урт хугацааны хамтын ажиллагааны урамшууллын хөтөлбөр хэрэгжүүлэх
- ◆ Борлуулалтыг урамшуулах хөтөлбөр

### Байршуулах стратеги ба оновчтой байршлыг тодорхойлох

- ◆ 5,000 гаруй шингэн хүнсний борлуулалтын цэг
- ◆ 6,000 гаруй харилцагч
- ◆ Борлуулалтын оновчтой арга хэрэгсэл
- ◆ Боломжит хямд үнэ, олон тоо
- ◆ Цэвэр усны зохистой болон байгаль орчинд ээлтэй ухаалаг хэрэглээний ач холбогдол
- ◆ Ивээн тэтгэлэг

#### Хуучин загвар



#### Шинэ брэнд



## ЗАХ ЗЭЭЛ ДЭХ VOYAGE БРЭНДИЙН ХЭРЭГЛЭЭ



**33.8 сая литр**

Борлуулалт  
биет үйлдвэрлэлээр



**+5,000**

Харилцагч



**+ 30%**

Зах зээлийн эзлэлт  
биет үйлдвэрлэлээр

Монгол Улсын савласан цэвэр усны хэрэглээ ба Voyage брэндийн борлуулалтын биет хэмжээ 2018-2023 оны 6-р сарын 30-нарх гүйцэтгэл ба 2023-2027 оны төсөөлөл, сая литр



2013-2022 CAGR: +11.3%

2018-2022 CAGR: +8.8%

2018-2022 CAGR: +11.7%

2022-2028 CAGR: +11.3%

2022-2028 CAGR: +19.1%

Дотоодын нийлүүлэлт болон импорт, экспортын хэмжээгээр тодорхойлсон нийт зах зээлд Үнэт цаас гаргагчийн эзлэх хувь 28.8 хувиас 32.1 хувь болж өссөнөөр зах зээлд эзлэх байр суурь нэмэгдсэн байна.

## САНХҮҮГИЙН ТҮҮХЭН ҮЗҮҮЛЭЛТ БА ТӨСӨӨЛӨЛ


### Үнэт цаас гаргагчийн орлогын эх үүсвэрүүд

Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого нь савласан цэвэр ус, түүхий эд материал болон үзүүлсэн үйлчилгээний орлогоос бүрдсэн.

- Нийт 2 төрлийн, 6 ялгаатай хэмжээний савлагаа бүхий савласан цэвэр усны борлуулалт нь орлогын гол эх үүсвэр бөгөөд нийт борлуулалтын 96.0 хувийг эзэлж байна.
- 2020 онд КОВИД-19 цар тахлын үед Үнэт цаас гаргагч нь мөхлөг, бөглөө ба савны бариулын бэлдэц зэрэг түүхий эдийн үнэ хямдарсан үед импортоор оруулж ирэн ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг компаниудад борлуулж орлогын нэмэлт эх үүсвэрийг бүрдүүлсэн юм. Үнэт цаас гаргагчийн түүхий эд материал борлуулалтын орлого нь нэг удаагийн шинж чанартай байсан бөгөөд үндсэн бизнес хэлбэрээр цаашид үргэлжлэхгүй. Тиймээс Үнэт цаас гаргагч нь 2023 оноос хойш бизнесийн үндсэн үйл ажиллагаа болох савласан цэвэр усны чиглэлээр дагнан ажиллаж байна.
- Үнэт цаас гаргагч нь өөрийн эзэмшлийн газрын тодорхой хэсгийг үйлдвэрлэлийн зориулалтаар түрээслэгч “Санвин” ХХК-д ашиглуулсны үйлчилгээний төлбөрийг авдаг бөгөөд Үнэт цаас гаргагч нь “Санвин” ХХК-аас зарим савлагааны хуванцар хуруу сав, бариул, бөглөөний бэлдэц хэвлэх үйлчилгээг авдаг.

### Борлуулалтын орлого ба цэвэр ашиг

2018-2023 оны 6-р сарын 30-нарх гүйцэтгэл ба 2023-2028 оны төсөөлөл, сая төгрөг



2018-2022 CAGR: +49.8%

2018-2022 CAGR: +73.1%

2022-2028 CAGR: +18.1%

2022-2028 CAGR: +32.6%

## САНХҮҮГИЙН ТҮҮХЭН ҮЗҮҮЛЭЛТ БА ТӨСӨӨЛӨЛ

Түүхэн 5 жилийн дундаж үзүүлэлтээс нийт борлуулсан савласан цэвэр усны борлуулалтын орлогын 62.4 хувийг том савлагаатай цэвэр ус, 37.6 хувийг амны цангаа тайлах жижиг савлагаатай цэвэр ус тус тус бүрдүүлсэн. 2023 оноос байгалийн хужраар эрдэсжүүлсэн Ph8.5 шүлтлэг 330 мл болон 500 мл савлагаатай цэвэр усыг зах зээлд нэвтрүүлсэн. Үнэт цаас гаргагч нь бүтээгдэхүүний нэр төрлийг хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн тогтмол хөгжүүлж ажилладаг бөгөөд бизнесийн тогтвортой хамтын ажиллагаа, орон нутгийн засаг захиргааны үйлдвэрлэлийг дэмжсэн бодлого, урт хугацааны тогтвортой өсөлтийг бий болгох салбар үйлдвэрийг Өмнөговь аймагт байгуулахаар бэлтгэл ажлаа хангаж байна.

Өмнөговь аймаг нь уул уурхайн стратегийн бус нутагт тооцогддог ба тус аймгийн оршин суугчдаас гадна уул уурхайн 30,000 гаруй ажилчид хүн тус аймагт зорчин очдог. Үүн дээр үндэслэн харахад савласан цэвэр усны томоохон хэрэглэгчид нь уул уурхайн компанийн ажилтнууд бөгөөд Өмнөговь аймагт уул уурхайн 80 гаруй орд, 14 туслан гүйцэтгэгч компани, 1,400 гаруй туслан гүйцэтгэгч компани үйл ажиллагаа явуулж байна. Өмнөговь аймгийн хөрөнгө оруулалтын чуулганаас гаргасан дата товхимолд дурдсанаар 2022 онд уул уурхайн 2 том компани орон нутгийн 125 аж ахуй нэгжийг 835 тэрбумын худалдан авалтаар дэмжсэн байна.

Үнэт цаасны танилцуулгыг бэлтгэх үеийн байдлаар Үнэт цаас гаргагчийн борлуулалтын гүйцэтгэлийн ихэнх хувийг Улаанбаатар хотын жижиглэн хүнсний худалдаа эрхлэгчид болон аймгийн төвийн жижиглэн хүнсний худалдаа эрхлэгчид тус тус бүрдүүлсэн байна.

### Үнэт цаас гаргагчийн харилцагчдын борлуулалтын гүйцэтгэлийн хувь



Иймд Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогын төсөөллийг нэгж бүтээгдэхүүний борлуулах тоо ширхэг болон нэгжийн үнэ дээр үнэ дээр тооцоолсон. Үүнд:


- ◆ Савласан цэвэр усны үнэ нь Монгол Улсын хүнсний салбарын инфляц, түүхий эдийн олон улс дээрх зах зээлийн үнэ, төгрөгийн ханшийн өөрчлөлтөөс хамаарч хэлбэлздэг тул тэдгээрийн тооцоолол дээр үндэслэн үнийн стратегийг гаргав.
- ◆ Борлуулалтын орлогын өсөлтөд гол нөлөөлөгч хүчин зүйл болох Өмнөговь аймгийн салбар үйлдвэрийн борлуулалтыг Өмнөговь аймгийн хүн ам зүй, бүс нутгийн эдийн засгийн үзүүлэлт дээр хийгдсэн судалгаа болон Үнэт цаас гаргагчийн өмнөх жилүүдийн борлуулалтын туршлага дээр суурилан таамагласан. 2028 он гэхэд Өмнөговь аймгийн үйлдвэрийн салбарын борлуулалт нийт борлуулалтын орлогын 23.7 хувийг бүрдүүлэх боломжтой гэж тооцоолов.
- ◆ 2022-2028 оны дунд хугацааны төсөөллөөр борлуулалтын орлого жилд дундаж 32 хувийн нийлмэл өсөлтийг үзүүлэх төсөөлөлтэй байна.

## САНХҮҮГИЙН ТҮҮХЭН ҮЗҮҮЛЭЛТ БА ТӨСӨӨЛӨЛ

Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого нь савласан цэвэр усны борлуулах тоо ширхэг болон нэгжийн үнээс хамааралтай байна. Иймд дараах үндэслэлд үндэслэн борлуулалтын орлогыг төсөөлөв.


### Ашигт ажиллагааны үзүүлэлтүүд

2018-2022 оны гүйцэтгэл ба 2023-2028 оны төсөөлөл, хувь




### Нийт эх үүсвэрийн бүтэц

2018-2023 оны 6-р сарын 30-нарх гүйцэтгэл ба 2023-2028 оны төсөөлөл, тэрбум төгрөг, хувь



### Нийт хөрөнгийн бүтэц

2018-2023 оны 6-р сарын 30-нарх гүйцэтгэл ба 2023-2028 оны төсөөлөл, тэрбум төгрөг, хувь



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь худалдаа, хүнсний үйлдвэрлэл, санхүүгийн салбаруудад 10 гаруй жил ажилласан бизнес удирдлага, санхүү чиглэлээр мэргэшсэн арвин туршлага бүхий гишүүдээс бүрддэг. Түүнчлэн ус хангамжийн инженерийн профессор, техникийн дэд профессор болон бизнесийн удирдлагын ухааны доктор зэрэгтэй ТУЗ-ийн хараат бус гишүүдтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.



**С.Алтантуяа**

ТУЗ-ийн дарга

“М-Си-Эс Кока Кола” ХХК, “Говь” ХК-д ажилласан 12 жилийн туршлагатай. 2019 оноос “Ти Эм Эл” ГХОХХК-д Дэд захирлаар ажиллаж байна.



**Д.Басандорж**

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль, Техникийн ухааны доктор, дэд профессор

“Монголын усны түншлэл” ТББ, Гүйцэтгэх захирал  
Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Байгал орчин

Инженерийн тэнхимийн эрхлэгч

Монгол Улсын Ариун Цэврийн Байгууллага, Ерөнхийлөгч



**С.Санасэр**

ТУЗ-ийн хараат бус гишүүн

МУИС – Эдийн засгийн сургууль, Ахлах багш

“Меррор Товер” ХХК, ТУЗ-ийн дарга

“Эс Пронисэс Консалтинг” ХХК, Үүсгэн байгуулагч

“Волтам” ХХК, ТУЗ-ийн гишүүн

“Эн Эф Трийс” ХХК, ТУЗ-ийн гишүүн



**Б.Баярзул**

ТУЗ-ийн гишүүн

Худалдаа, санхүүгийн салбарт 10 жилийн туршлагатай. 2021 оноос “Ти Эм Эл” ГХОХХК-д Ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байна. Татварын мэргэшсэн зөвлөх ба Мэргэшсэн нягтлан бодогч.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



**Х.Хүмүүжил**

ТУЗ-ийн гишүүн

Худалдааны салбарт 10 жилийн туршлагатай. 2014 оноос “Ти Эм Эл” ГХОХХК-д Нягтлан бодогчоор ажиллаж байна.



**Б.Амарбаясгалан**

ТУЗ-ийн гишүүн

Худалдааны салбарт 8 жилийн туршлагатай. 2022 оноос “Ти Эм Эл” ГХОХХК-д Хуулийн зөвлөхөөр ажиллаж байна.



**О.Сансар**

ТУЗ-ийн гишүүн

Худалдаа, уул уурхайн салбарт ажилласан 9 жилийн туршлагатай. 2019 оноос “Ти Эм Эл” ГХОХХК-д Санхүүгийн менежерээр ажиллаж байна.



**Б.Ундрал**

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Санхүүгийн салбарт 9 жилийн туршлагатай. 2018 оноос “Ти Эм Эл” ГХОХХК-д Хөрөнгө оруулалт хариуцсан дэд захирлаар ажиллаж байна.



## УДИРДЛАГЫН БАГ



### Х.Тэгшээ

Гүйцэтгэх захирал

Худалдаа, хүнсний үйлдвэрлэл, барилга, хуванцар дахин боловсруулах салбарт 18 жилийн туршлагатай.

2024 оноос “Эм Жи Эл Акуа” ХХК, Гүйцэтгэх захирал

2023 оноос “Эс И Эс Эл Смарт Солюшн” ХХК, Ерөнхий захирал

2021 оноос “ТЖТБ” ХХК, Ерөнхий захирал, ТУЗ-ийн гишүүн

2018 оноос “Ньюгор” ХХК, Ерөнхий захирал

2017 оноос “Эм Пластик” ХХК, Ерөнхий захирал

2013 оноос “Ти Эм Эл Трейд” ХХК, Ерөнхий захирал

2006 оноос “Ти Эм Эл” ГХОХХК, Ерөнхий захирал



### Б.Бат-Оргил

Борлуулалтын албаны дарга

“М-Си-Эс Кока-Кола” ХХК-д ажилласан 15 жилийн туршлагатай. 2021 оноос “Эм Жи Эл Акуа” ХХК-д Борлуулалтын албаны даргаар ажиллаж байна.



### Б.Дашзэвэг

Түгээлтийн албаны дарга

“АПУ Трейдинг” ХХК, “Витафит Групп” ХХК, “Таван богд групп” ХХК-д ажилласан 17 жилийн туршлагатай. 2021 оноос “Эм Жи Эл Акуа” ХХК-д Түгээлтийн албаны даргаар ажиллаж байна.

## УДИРДЛАГЫН БАГ



**Н.Магсаржав**

Үйлдвэрийн менежер

Хүнсний үйлдвэрлэлийн салбарт ажилласан 14 жилийн туршлагатай. 2023 оноос “Эм Жи Эл Акуа” ХХК-д Үйлдвэрийн менежерээр ажиллаж байна.



**Н.Бямбацэцэг**

Технологич

Хүнсний үйлдвэрлэлийн салбарт ажилласан 16 жилийн туршлагатай. 2023 оноос “Эм Жи Эл Акуа” ХХК-д Технологичоор ажиллаж байна.



**Д.Бат-Ирээдүй**

Ахлах нягтлан бодогч

Хүнсний үйлдвэрлэлийн салбарт ажилласан 16 жилийн туршлагатай. 2023 оноос “Эм Жи Эл Акуа” ХХК-д Технологичоор ажиллаж байна.



**Б.Ариунжаргал**

Хөдөлмөрийн аюулгүй байдал,  
эрүүл ахуй хариуцсан ажилтан

Хүнсний үйлдвэрлэлийн салбарт ажилласан 13 жилийн туршлагатай. 2021 оноос “Эм Жи Эл Акуа” ХХК-д Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн хариуцсан ажилтнаар ажиллаж байна.



**Б.Мөнхцолмон**

Захиргаа хүний нөөцийн албаны дарга

Хүнсний үйлдвэрлэлийн салбарт ажилласан 11 жилийн туршлагатай. 2023 оноос “Эм Жи Эл Акуа” ХХК-д Захиргаа, хүний нөөцийн албаны даргаар ажиллаж байна.

## ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭЗЭМШИЖ БУЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БА ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХ

Voyage брэндийн савласан цэвэр усыг үйлдвэрлэж эхэлсэн цагаас хойш шаардлагатай тусгай зөвшөөрлүүд болон стандартуудыг нэвтрүүлсээр ирсэн бөгөөд цаашид тус зах зээл дахь үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинэ зах зээлд үйлчилгээ нэвтрүүлэх тохиолдолд мөн адил зарчмыг баримтлан зохих тусгай зөвшөөрлүүдийг зохицуулах мэргэжлийн байгууллагуудаас шинэ эр авах, сунгах ажлуудыг мэргэжлийн түвшинд зохион байгуулж, хүнсний аюулгүй байдлын стандартуудыг тогтмол мөрдөж ажиллаж байна.

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагааныхаа онцлог, хүрээнд хамааралтай дараах тусгай зөвшөөрөл болон барааны тэмдгийг эзэмшиж байна.



### Ус ашиглах эрхийн бичиг

2015 оны 02-р сарын 04-ний өдөр олгогдсон

Сонгино-хайрхан дүүргийн 7-р хороонд байршилтай усны нөөцөөс хоногт 73.82 м3 шоо метр ус ашиглах зөвшөөрөл олгогдсон ба зөвшөөрлийн хугацаа нь 3 жил тутамд сунгагддаг. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийг хүртэл хүчинтэй байна.



### Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл

2023 оны 09-р сарын 29-ны өдөр олгогдсон

Туул голын сав газрын захиргаанаас Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл авсан ба ус бохирдуулсны төлбөрийн гэрээ болон дүгнэлтийг зөрчөөгүй тохиолдолд зөвшөөрлийг жил бүр сунгасанд тооцдог. Үнэт цаасны танилцуулгыг бэлтгэх үеийн байдлаар 2024 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр хүртэл хүчинтэй байна.



### Вояж

2012-2032 оны 03-р сарын 21-ний өдөр хүртэл хүчинтэй



Үнэт цаас гаргагч нь 2012 оны 03 сарын 21-ний өдөр барааны тэмдэгийг бүртгүүлэх хүсэлт, мэдүүлгийг гаргаж, 40-0010129 тоот барааны тэмдгийн гэрчилгээг авсан.



### Voyage

2018-2028 оны 04-р сарын 27-ны өдөр хүртэл хүчинтэй

Үнэт цаас гаргагч нь уг барааны тэмдэгийг бүртгүүлэх тухай хүсэлт, мэдүүлгийг 2018 оны 04 сарын 27-ны өдөр гаргаж, 40-0019158 тоот барааны тэмдгийн гэрчилгээг авсан.

# БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЗАСАГЛАЛЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

## Байгаль, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөл

### Эко савлагаа

- Нэмэлт өнгө оруулагчгүй
- Энгийн материал хийцлэлтэй
- Хөнгөн савлагаа

### Хүртээмжтэй цэвэр ус

- Нийгмийн бүхий л давхаргад зориулсан
- Цэвэр усны зохистой хэрэглээний ойлголтыг түгээдэг

### Тойргын эдийн засгийг дэмжигч

- Хуванцар савны хог хаягдлыг цуглуулж дахин боловсруулалтад өгдөг
- CO2 ялгаруулалтыг боломжит бага хэмжээнд барьдаг
- 200 тонн хуванцар сав байгальд хаягдахаас сэргийлсэн



## Бүтээгдэхүүн хөгжүүлэлт

### Олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх

- Цэвэр усны зохистой хэрэглээ
- Хуванцар савны хог хаягдлын ашиглалт

### Хүний нөөцийн бодлого, ажлын таатай орчныг бүрдүүлэх

- Ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагаа
- Шилдэг ажил олгогч, Шилдэг шимтгэл төлөгч Тогтвортой ажлын байраар хангагч

### Зохистой хөдөлмөрийг дэмжих



## Байгууллагын засаглалын нөлөөлөл

Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан болон удирдлагын багийн гишүүд нь МУИС-ийн Бизнесийн сургуулийн зохион байгуулдаг “Компанийн засаглал” сургалтад хамрагдаж, Компанийн засаглалын үндэсний зөвлөлөөс олгодог гэрчилгээг авсан байна. Олон нийтэд хувьцаагаа анх удаа санал болгож хувьцаат компанийн статустай болох энэхүү томоохон өөрчлөлт, сайжруулалтын хүрээнд Үнэт цаас гаргагч нь СЗХ-оос гаргасан “Компанийн засаглалын кодекс”-ийг үйл ажиллагаандаа мөрдөж, засаглалыг бэхжүүлнэ.

---

## ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗАХ ЗЭЭЛ БА СТРАТЕГИ

- ◆ Олон улсын савласан цэвэр усны зах зээл
- ◆ Монгол Улсын савласан цэвэр усны зах зээл
- ◆ Дунд хугацааны төлөвлөгөө
- ◆ Эрсдэлийн хүчин зүйлс ба удирдлага

## ОЛОН УЛСЫН САВЛАСАН ЦЭВЭР УСНЫ ЗАХ ЗЭЭЛ

**ЗАХ ЗЭЭЛ**  
**1,225 ТЭРБУМ**  
**АМ.ДОЛЛАР**

2021 оны байдлаар

**ЗАХ ЗЭЭЛИЙН**  
**17-24 ХУВЬ**

2021 оны байдлаар

Согтууруулах бус  
шингэн хүнс




Согтууруулах  
шингэн хүнс



Шингэн хүнсний ангилал

Дэлхийн савласан усны зах зээлийн дүн, улсаар, тэрбум ам.доллар  
2021 он



Эх сурвалж: НҮБ-ын Их Сургуулийн Ус, Байгаль орчин, Эрүүл мэндийн хүрээлэн  
"Дэлхийн савласан усны зах зээл" тайлан, 2023 он


**МОНГОЛ УЛСЫН САВЛАСАН**  
**ЦЭВЭР УСНЫ ЗАХ ЗЭЭЛ**  
**0.05-0.1 ТЭРБУМ**  
**АМ.ДОЛЛАР**

## ОЛОН УЛСЫН САВЛАСАН ЦЭВЭР УСНЫ ЗАХ ЗЭЭЛ

2021 оноос хойш дэлхийн савласан усны зах зээл нь жил бүр 5.2 хувийн жинлэсэн дундаж нийлмэл өсөлтийг үзүүлж байгаа ба бусад шингэн хүнс, тухайлбал, кофены зах зээлийн 3.5 хувийн жинлэсэн дундаж нийлмэл өсөлтөөс хурдацтай өссөн. 2022 оноос энэхүү зах зээлийн өсөлт 2021 оноос хурдацтай болж жинлэсэн дундаж 7.0 хувийн нийлмэл өсөлтийг үзүүлж, 2025-2030 онд зах зээлийн хэмжээ 500 тэрбум ам.долларт хүрнэ гэж BlueWeave, Grandview Research, Statista зэрэг олон улсын судалгааны байгууллагууд таамаглаж байна. Үүнээс **шингэн хүнсний зах зээлд савласан усны зах зээл өндөр өсөлтийг үзүүлэх боломжтой нь харагдаж буй юм.**

Сүүлийн 10 жилийн савласан цэвэр усны зах зээлийн өсөлт дунджаар 73.0 хувьд хүрсэн нь бусад зах зээлүүдтэй харьцуулахад хамгийн далайцтай өсөж буй зах зээлийн нэгд зүй ёсоор тооцогдож байна.

Дэлхийн савласан усны зах зээлийн биет хэмжээ, бүс нутгаар, сая литр  
2010-2021 он



Эх сурвалж: Bottled Water: An Evidence-Based Overview of Economic Viability, Environmental Impact, and Social Equity, 2023 он

## ОЛОН УЛСЫН САВЛАСАН ЦЭВЭР УСНЫ ЗАХ ЗЭЭЛ

Олон Улсын савласан цэвэр усны нийгэмлэгүүдийн зөвлөл, Олон Улсын савласан цэвэр усны холбоо, Ундны усны судалгааны сан зэрэг олон улсын байгууллагуудаас савласан цэвэр усны төрлүүдийг эх үүсвэр, химийн найрлага, хийжүүлсэн эсэхээс хамааруулан ангилдаг ба олон улсын түвшинд савласан усыг үндсэн 3 төрөлд хуваадаг.

Байгалийн эрдэст ус


Рашаан ус

Цэвэршүүлсэн ус


Дээрх ангиллуудаас гадна хийжүүлсэн, артезийн, мөстлийн ус гэх зэрэг савласан усны дэд ангиллууд байдаг.

Байгалийн эрдэст усыг гүнээс олборлон хэрэглээнд шууд хэрэглэдэг бол рашаан усыг гүнээс газрын гадарга дээр гарч ирэх үед олборлон ашигладаг. Цэвэршүүлсэн ус нь гол мөрөн, нуур, гүний усыг нэрэх, ионгүйжүүлэх, урвуу осмос зэрэг аргуудыг ашиглаж усыг цэвэршүүлж унданд хэрэглэхэд тохиромжтой болгосон ус юм.

Савласан усны төрлүүд ба хэрэглээ, тэрбум литр, 450 тэрбум литрт эзлэх хувь  
2021 он



Савласан усны төрлүүд ба орлогын дүн, тэрбум ам.доллар, 270 тэрбум ам.долларт эзлэх хувь  
2021 он



Эх сурвалж: НҮБ-ын Их Сургуулийн Ус, Байгаль орчин, Эрүүл мэндийн хүрээлэн "Дэлхийн савласан усны зах зээл" тайлан, 2023 он

Савласан усны зах зээлд цэвэршүүлсэн ба байгалийн эрдэст усны зах зээл бусад төрлийн усны зах зээлээс хурдацтай өсөж 2018 оноос жилд дунджаар тогтмол 10.0 хувь, 12.0 хувиар тус тус өссөн. Ижил хугацаанд, байгалийн бусад төрлийн усны зах зээлийн өсөлт харьцангуй бага буюу жилд ойролцоогоор 5.0 хувиар өссөн байна.



## МОНГОЛ УЛСЫН САВЛАСАН ЦЭВЭР УСНЫ ЗАХ ЗЭЭЛ



2018-2022 оны дундаж үзүүлэлт

Монгол Улсын савласан усны зах зээлийн хэмжээг хүн амын хэрэгцээ болон үйлдвэрлэлийн статистик, импорт ба экспортын статистикийг үндэслэн тодорхойлох боломжтой. Дотоодын нийлүүлэлт болон импорт, экспортын хэмжээгээр тодорхойлсон нийт зах зээлд Үнэт цаас гаргагчийн эзлэх хувь 2022 оны байдлаар 32.1 хувь байна.


### Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх хувь

2018-2022 он

Үзүүлэлт, мянган тонн	2018	2019	2020	2021	2022	2023Н1
Савласан усны үйлдвэрлэл	73,740	98,641	74,606	98,362	100,463	55,032
Савласан усны импорт	1,556	2,119	1,869	3,349	5,079	1,296
Савласан усны экспорт	12.9	52.2	0.0	-	0.1	0.1
Монгол Улсын савласан цэвэр усны зах зээл	75,284	100,707	76,475	101,711	105,542	56,328
Үнэт цаас гаргагчийн борлуулалт	21,714	27,741	26,907	29,890	33,847	15,889
Эзлэх хувь	28.8%	27.5%	35.2%	29.4%	32.1%	28.2%

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол, Үндэсний Статистикийн Хороо, Гаалийн цахим үйлчилгээний систем

### Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх хувь




## МОНГОЛ УЛСЫН САВЛАСАН ЦЭВЭР УСНЫ ЗАХ ЗЭЭЛ

Дэлхийн банкны “Монгол Улс, Өмнөд говийн бүс: Гидроэкономик шинжилгээ” судалгаанд хүн амын өсөлт нь хүн амын ус хэрэглээний цаашдын өсөлтөд нөлөөлөх гол хүчин зүйл гэж тусгасан ба 2013-2022 онуудад савласан усны зах зээлийн хэмжээ ба Монгол Улсын нийт хүн амын тоог үндэслэн жишиг нэг хүнд ногдох савласан усны жилийн хэрэглээг тооцсон байдаг.

### Нэг хүний савласан цэвэр усны жилийн хэрэглээ ба харьцуулалт

2013-2022 он



Эх сурвалж: Олон улсын савласан усны холбоо, Statista олон улсын судалгааны байгууллага, Үндэсний статистикийн хороо, Гаалийн байгууллага


Савласан усны зах зээлд хүн амын өсөлт, өрхийн дундаж орлого, хэрэглэгчийн зан төлөв, тухайн бүс нутгийн аж үйлдвэржилт зэрэг хүчин зүйлүүд нөлөөлдөг бөгөөд Монгол Улсын савласан цэвэр усны хэрэглээ 2018-2020 оны олон улсын дундаж хэрэглээ 51.9-52.4 литртэй харьцуулахад бага байна. Гэсэн хэдий ч Монгол Улсын нэг хүнд ногдох савласан усны жилийн хэрэглээ 10 жилийн хугацаанд тасралтгүй өссөн байна.

## МОНГОЛ УЛСЫН САВЛАСАН ЦЭВЭР УСНЫ ЗАХ ЗЭЭЛ

### МОНГОЛ УЛСЫН САВЛАСАН ЦЭВЭР УСНЫ ХЭРЭГЛЭЭ 5 ЖИЛИЙН ХУГАЦААНД 1.4 ДАХИН НЭМЭГДСЭН

САХРЫН АГУУЛАМЖТАЙ БҮТЭЭГДЭХҮҮНЭЭС ТАТГАЛЗАЖ ЭРҮҮЛ  
ОРГАНИК ХЭРЭГЛЭЭГ ЧУХАЛЧЛАХ БОЛСОН

2018 ← → 2022




САВЛАСАН ЦЭВЭР УСНЫ ХЭРЭГЛЭЭ  
+ 30,258 САЯ ЛИТР

Энэхүү нийгмийн хандлагын өөрчлөлт нь савласан цэвэр усны зах зээлд эергээр нөлөөлнө гэж үзсэн тул Үнэт цаас гаргагч нь савласан цэвэр усны зах зээлийг ирэх 5 жилийн хугацаанд жилийн 11.7 хувиар өснө гэж тооцоолж байна.

Монгол Улсын савласан усны зах зээлийн биет хэмжээ, сая литр

2018-2022 он, 2023-2028 оны төсөөлөл



## ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үнэт цаас гаргагчийн стратеги нь эрүүл ахуйн шаардлага хангасан савласан цэвэр усыг Монгол Улс даяар боломжийн үнээр борлуулах чиглэлд төвлөрч байгаа бөгөөд урт хугацааны тогтвортой хөгжил, тогтвортой өсөлтөд чиглэсэн бодлогыг үйл ажиллагаандаа баримтлан ажиллана. Үнэт цаас гаргагч нь дунд хугацааны стратегийн хүрээнд бизнесийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, өрсөлдөөний давуу тал үүсгэх дараах зорилтуудыг тодорхойлсон.

### Нийлүүлэлтийн тасралтгүй байдлыг хангах

Усны савлагааны жинг үе шаттайгаар бууруулах, хүнсний стандартын шаардлага хангасан дахин боловсруулсан түүхий эдийг ашиглаж улмаар үйлдвэрлэлийн өртгийг бууруулж, хуванцар савны ухаалаг хэрэглээг бий болгоно. Үүний үр дүнд хэмнэлттэй, боломжийн үнийн бодлогыг үргэлжлүүлэн баримтална. Мөн Улаанбаатар хотод түгээлтийн менежментийг сайжруулж дэлгүүрүүд дэх нийлүүлэлтийн хомсдолыг нөхнө.

### Харилцагчдын тоог нэмэгдүүлэх

ХоРеКа сувагт үйл ажиллагаа явуулдаг харилцагчидтай хамтын ажиллагааг нэмэгдүүлж, мөн орон нутагт борлуулалтын сувгийг тэлж хүртээмжтэй байдлын нэмэгдүүлнэ. Харилцагчдад чиглэсэн урамшуулал, идэвхжүүлэлтийн хөтөлбөрийг бий болгосноор урт хугацааны тогтвортой хамтын ажиллагааг бэхжүүлнэ. Түүнчлэн судалгаа хөгжүүлэлтийн хөтөлбөрийг нэвтрүүлэх хэлбэрээр үйл ажиллагааны сайжруулалтыг тогтмол хэрэгжүүлэн ажиллана.

### Бүтээгдэхүүн төрөлжилтийг нэмэгдүүлэх

Хэрэглэгч бүрийн хэрэглээний онцлог, амьдралын хэв маягт нийцсэн бүтээгдэхүүний нэр төрөл болон савлагааны сонголтуудыг үе шаттайгаар зах зээлд нийлүүлнэ.

### Борлуулалтын хил хязгаараа тэлэх

Өмнөд бүс, Зүүн бүс, Баруун бүс, Төвийн бүс гэсэн бүсчилсэн тэлэлтийг хийнэ. Үүнд:

- Монгол Улсын өнцөг булан бүрд чанарын шаардлага хангасан савласан цэвэр усыг боломжит хямд үнээр түгээх үйлдвэрлэлийн цогцолборыг стандартын шаардлага хангасан цэвэр усны хомсдолтой нүүр тулаад буй Өмнөговь аймагт бий болгоно. Өмнөговь аймагт оршин суудаг, уул уурхайн нөлөөллийн бүсэд ажилладаг хэрэглэгчдэд чанарын шаардлага хангасан цэвэр ус хэрэглэх боломжийг бүрдүүлэхээс гадна ойролцоох аймаг, сумдад савласан цэвэр усыг хямд зардлаар түгээнэ.
- Ирэх жилүүдэд Бүгд Найрамдах Узбекистан Улсад цэвэр усны үйлдвэрийг байгуулахаар төлөвлөж байгаа ба одоогоор зах зээлийн судалгаа, бичиг баримтын бүрдлийн ажлууд эхэлсэн байна.

## ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

### Бүтээгдэхүүн хөгжүүлэлт



Өдөр тутмын ундны цэвэр усаа худалдааны байгууллагаас худалдан авч хэрэглэдэг хэрэглэгчдэдээ зориулсан 9 литрийн савлагаатай цэвэр ус



Монгол орны цаг уураас шалтгаалан хүний биед нийтлэг дутагддаг витамин Д-ээр баяжуулсан эрдэст ус



Гэр бүлийн хэрэглээнд зориулагдсан хамгийн том савлагаа. Авч явахад хялбар бариултай, баллонтой ус буцалгагчид суурилуулан ашиглах боломжтой ухаалаг бөглөөтэй.



Монгол хүүхдүүдийн 75.9% нь фторын дутагдлаас үүссэн шүд цоорох өвчлөлтэй байна. Тус фторын хэрэгцээг зохимжит хэмжээгээр нөхөх фторжуулсан цэвэр ус




Шилэн савлагаатай цэвэр ус

## ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

### “South Gobi Voyage”

Өмнөговь аймгийн усны чанарын түвшин, нийт дээж авсан худгийн тоон дүнд эзлэх хувь  
2018 он



*Эх сурвалж: “Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны өнөөгийн байдал-2018” түүвэр судалгааны тайлан*

Нөгөөтээгүүр, уул уурхайн салбарт ажилладаг хүмүүс хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажил үүргээ эрхэлдэг тул Улаанбаатар хотын төвийн оршин суугчидтай харьцуулахад ундны цэвэр усны хэрэгцээ өндөр байдаг.

“Монголын Өмнөд Говийн бүсийн Гидроэкономик шинжилгээ”-ний тайланд дурдсанаар Өмнөговь аймгийн Уул Уурхайн нөлөөллийн бүс дэх хүнсний үйлдвэрлэлийн усны эрэлт нь 2019 оны байдлаар 32,450 м<sup>3</sup>/жил буюу нэг жилд 32,450 тонн савласан цэвэр усны эрэлт үүсдэг гэсэн тооцооллыг гаргасан байна. Энэ нь тус оны Монгол Улсын нийт савласан усны үйлдвэрлэлийн 32 хувийг эзэлж байна. Өмнөговь аймгийн Уул Уурхайн нөлөөллийн бүст Даланзадгад, Ханбогд, Ханхонгор, Цогтцэций, Баян-Овоо, Мандал-Овоо, Номгон, Баяндалай, Хүрмэн сумууд багтдаг байна.

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагч нь Өмнөговь аймгийн савласан цэвэр усны хэрэглээний 10-12 хувийг хангасан бөгөөд 2024 оноос тус аймагт цэвэр усны үйлдвэр ашиглалтад орсноор тус зах зээлийн 30-50 хувийг бүрэн хангах боломжтой болж, аливаа тээврийн зардал, жижиглэн дэлгүүрийн үнийн нэмэгдэлгүйгээр шууд үйлдвэрээс нийлүүлэх юм. Үнэт цаас гаргагчийн тооцоолж байгаагаар Өмнөговь аймагт үйлдвэрийн 330 грамм, 0.5 литр, 1.5 литрийн савлагаа бүхий үйлдвэрийн жижиг шугам, 4.5 литрийн савлагаа бүхий үйлдвэрийн том шугамыг суурилуулах төлөвлөгөөтэй байна.

## ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС БА ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Үнэт цаас гаргагч нь савласан цэвэр ус үйлдвэрлэгч аж ахуйн нэгжийн хувьд хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд дараах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлдэг.

- 1  **FSSC 22000** стандартыг нэвтрүүлснээр хүнсний аюулгүй байдлаас гадна хүнсний чанар, хамгаалалт, хуурамч бүтээгдэхүүнээс сэргийлэх цогц ажиллагааг олон улсын Дэлхийн хоол хүнсний аюулгүй байдлын санаачилгын дор хангаж үйл ажиллагаагаа явуулдаг;
- 2  Түүхий эд материалыг хүлээн авахаас эхлэн үйлдвэрлэлийн бүх үе шатыг хянаж, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг  стандартыг нэвтрүүлж үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаг;
- 3 Усны чанар, аюулгүй байдалд улирал тутам “Хүнсний Аюулгүй Байдлын Үндэсний Лавлагаа Лаборатори”, “Геологи Судалгаа Шинжилгээний Төв Лаборатори”, “Усны Газар Хяналтын Төв Лаборатори”, “Номин Эко Стандарт хөндлөнгийн итгэмжлэгдсэн лаборатори” зэрэг итгэмжлэгдсэн байгууллагуудаар усны дээжийн хяналт шинжилгээг гүйцэтгүүлдэг. Мөн үйлдвэрийн ээлж бүрээр 2 цаг тутамд өөрийн дотоод лабораторид усны дээжийн шинжилгээг хийдэг;
- 4 Бүтээгдэхүүний чанарыг тогтмол барих, чанарын давтан шинжилгээг хийж, баталгаажуулах;
- 5 Бүтээгдэхүүнд гаднын биетээр бохирдох эрсдэл гарахаас сэргийлэн харилцагчдад хадгалалт болон тээвэрлэлтийн нөхцөл шаардлагыг таниулах мэдээлэл, сургалтыг тогтмол хийх;
- 6 Бүтээгдэхүүний стандартын горим алдагдахаас сэргийлэн чанарын албаны ажилчдыг сургах, дадлагажуулах, хяналтыг сайжруулах.

---

## ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

- ◆ Үнэ тогтоосон үндэслэл
- ◆ Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт
- ◆ Хувьцааны онцлог
- ◆ Үнэт цаас худалдан авах захиалга өгөх заавар
- ◆ Үнэт цаастай холбоотой эрсдэлийн хүчин зүйлс



## ҮНЭ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

Үнэт цаасны зах зээл оролцогч этгээдэд үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хөндлөнгийн байгууллага болох “Итгэлт-Эстимэйт” ХХК нь Үнэт цаас гаргагчийн хувьцаагаа олон нийтэд анх удаа санал болгох үйл ажиллагаанд зориулж зах зээлийн үнэ цэнийг харьцуулалтын, орлогын болон хөрөнгөд суурилсан аргуудаар үнэлсэн бөгөөд Орлогын хандлагын мөнгөн гүйлгээ хорогдуулан тооцох аргаар хийсэн үнэлгээнд 100 хувь ач холбогдол өгсөн болно. Компанийн ирээдүйн төсөөллийг дараах үндэслэлд суурилан тооцсон. Үүнд:

7.5%

### Урт хугацааны өсөлт

Сүүлийн 5 жилийн цэвэр борлуулалтын орлогын өсөлт болон Монгол Улсын инфляцын дундаж хувьд үндэслэж тооцоолсон

24.8%

### Хорогдуулалтын хувь

САРМ загвар ашиглан хорогдуулалтын хувийг тооцоолсон

14.24%

### Хяналтгүйн хувь оролцооны хямдруулалт

Жижиг хувьцаа эзэмшигчдийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал болон жижиг хувьцаа эзэмшигчдийн хямдруулалт (minority discount) олгож 174 төгрөгөөр олон нийтэд санал болгож байна

66,458.4 Сая ₮

Компанийн бизнесийн үнэлгээ

174 ₮

Нэгж хувьцааны үнэ

174 ₮

Үнэт цаас гаргагч болон Андеррайтерийн зүгээс зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал болон жижиг хувьцаа эзэмшигчийн хямдруулалт (minority discount) буюу **14.24 хувийн хөнгөлөлттэй** үнээр буюу **174 төгрөгөөр** олон нийтэд санал болгохоор Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хурлын №23/12/12 тоот тогтоолоор шийдвэрлэсэн

## ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Үнэт цаас гаргагч нь дунд хугацааны бизнес төлөвлөгөөний хүрээнд татан төвлөрүүлсэн хөрөнгийг дараах байдлаар зарцуулахаар төлөвлөж байна.

Татан төвлөрүүлэх дүн

**15,234,677,184 ₮**

Өмнөговь аймагт савласан цэвэр усны үйлдвэрийн барилга байгууламж байгуулахаар төлөвлөж байна. Өмнөговь аймаг нь уул уурхайн стратегийн бус нутагт тооцогддог бөгөөд тус аймгийн оршин суугчдаас гадна уул уурхайн 30,000 гаруй ажилчид хүн тус аймагт зорчин очдог байна. Үүн дээр үндэслэн харахад савласан цэвэр усны томоохон хэрэглэгчид нь уул уурхайн компанийн ажилтнууд бөгөөд Өмнөговь аймагт уул уурхайн 80 гаруй орд, 14 туслан гүйцэтгэгч компани, 1,400 гаруй туслан гүйцэтгэгч компани үйл ажиллагаа явуулж байна.

Том савлагаатай бүтээгдэхүүний сав үлээх, савлах, багцлах цогц систем бүхий үйлдвэрлэлийн шугамыг суурилуулж, үйлдвэрийн хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Улмаар том савлагаатай савласан цэвэр усны борлуулалтыг нэмэгдүүлэн үйлдвэрлэлийн бүтээмж өсөж, улмаар зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэх боломжтой.

**6.1 тэрбум ₮ 39.8%**

Орон нутагт савласан цэвэр усны үйлдвэр нээх төслийн хөрөнгө оруулалт

**29.5% 4.5 тэрбум ₮**

Том савлагаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шугам

**4.1 тэрбум ₮ 27.0%**

Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт

**3.6% 0.5 тэрбум ₮**

Тогны хэлбэлзлийн хяналтыг сайжруулах шинэ трансформатор

Үйл ажиллагаанд шаардлагатай эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд зарцуулж, үйл ажиллагааг хэвийн тасралтгүй байдлыг хангахад чиглэнэ.

Тогийн хэлбэлзлийн хяналтыг сайжруулахын Улаанбаатар хот дах үйлдвэртээ суурилуулахаар төлөвлөж байна.

## ХУВЬЦААНЫ ОНЦЛОГ

1



Инфляц, ханшийн өсөлтөөс хамгаалах хөрөнгө оруулалт

2



Үндэсний брэнд бүтээгдэхүүн

3



Хамгийн том савласан цэвэр усаар дагнасан үйлдвэр

4



Нийлүүлэлтийн тасралтгүй байдлыг хангасан

5



Байнгын өсөлттэй зах зээлд үйл ажиллагаа явуулдаг

6



Чадварлаг хүний нөөц

7



Тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулагч

8



Компанийн 26.73%-ийг олон нийтэд санал болгож байна

9



Бизнесийн үнэлгээнээс 14.24%-р хямдруулалттай үнэлгээ


10



Үнэ тогтворжуулах хөтөлбөрийг IPO үнээс 15%-р буурахад хэрэгжүүлнэ

## ҮНЭТ ЦААС ХУДАЛДАН АВАХ ЗАХИАЛГА ӨГӨХ ЗААВАР

Үнэт цаас гаргагчийн санал болгож буй Үнэт цаасыг худалдан авахаар төлөвлөж буй хөрөнгө оруулагч нь хувьцааны анхдагч зах зээлийн арилжаанд дор дурдсан зааврын дагуу оролцоно.



## ҮНЭТ ЦААСТАЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС

Хөрөнгө оруулагч нь Үнэт цаас худалдан авч эзэмшихийн өмнө Үнэт цаас гаргагчтай холбоотой эрсдэлийн хүчин зүйлсээс гадна дараах эрсдэлийн хүчин зүйлстэй танилцсан байвал зохистой. Андеррайтер болон Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчийг Үнэт цаас худалдан авч эзэмшихийн өмнөх шийдвэрээ гаргахад нь болзошгүй эрсдэлийн хүчин зүйлсийн талаар зөвхөн зөвлөмж хэлбэрээр сануулах, мэдээлэл хүргэх байдлаар тусгасан болохыг анхаарна уу.

Үнэт цаас эзэмшихтэй холбоотой үүсэж болох эрсдэлийн хүчин зүйлсийг дурдсан явдал нь тэдгээр эрсдэлүүд одоо болон ирээдүйд бүгд учирч тохиолдоно гэсэн утга агуулгыг илэрхийлээгүй, зөвхөн магадлал таамаглал болохыг дурдаж байна. Энэ бүлэгт тусгагдсан, эсхүл урьдчилан таамаглагдаагүй эрсдэл үүсэх, бий болох тохиолдолд хувьцааны үнэ буурч, хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтаа бүхэлд нь эсхүл зарим хэсгийг алдаж болзошгүйг үгүйсгэхгүй бөгөөд Андеррайтерууд болон Үнэт цаас гаргагч нь эрсдэлийн хүчин зүйлсийг үүсгэхгүй байх талаар аливаа баталгааг гаргаагүй болно.

Хөрөнгө оруулагчид энэхүү Үнэт цаасны танилцуулгад агуулагдсан мэдээлэл, бусад шаардлагатай баримт материал болон өөрийн санхүүгийн нөхцөл байдлыг харгалзан Үнэт цаасанд хөрөнгө оруулах эсэх шийдвэрээ сайтар судалж гаргах нь зүйтэй гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

### Хувьцааны хөрөнгө оруулалтын эрсдэл

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн бүр эрсдэлтэй байх ба хувьцааны хувьд үнийн хэлбэлзэл багтана. Үнэт цаас гаргагч нь нээлттэй зах зээл дээрх үнийн амлалт, баталгаа гаргах боломжгүй бөгөөд хувьцааны эрэлт, нийлүүлэлт болон зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалан хувьцааны зах зээлийн үнэ тогтоно. Мөн компанийн үйл ажиллагаа, цаашдын хэтийн төлөвтэй холбоотойгоор олон нийтэд цацагдах эерэг болон сөрөг мэдээллээс шалтгаалж хувьцааны үнэ өсөх, буурахад нөлөөлдөг.

### Хөрвөх чадварын эрсдэл

Хувьцааны эрэлт, нийлүүлэлтээс шалтгаалж хувьцааны арилжааны идэвх хамаардаг. Үүнтэй холбоотойгоор Үнэт цаас гаргагчаас арилжааны идэвхийн талаар баталгаа гаргах боломжгүй тул Хөрөнгө оруулагч их хэмжээний арилжаа хийсэн тохиолдолд тухайн үеийн арилжааны идэвхтэй холбоотойгоор хүссэн хэмжээгээр, эсхүл хүссэн үнэ ханшаар худалдах, худалдан авах боломжгүй байх магадлалтай.

### Ногдол ашигтай холбоотой эрсдэл

Үнэт цаасны ногдол ашигтай холбоотой шийдвэрийг ТУЗ-өөс гаргаж, ХЭХ-аар батлах бөгөөд ирээдүйд ногдол ашиг тараахгүй байх, хөрөнгө оруулагчийн хүлээлтээс бага дүнгээр ногдол ашиг тараах зэрэг эрсдэлүүдтэй хөрөнгө оруулагчид тулгарах боломжтой.

## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ

Энэхүү Үнэт цаасны танилцуулгыг бэлтгэх үеийн байдлаар Т.Дөлгөөн Гүйцэтгэх захирлын үүргийг гүйцэтгэж байсан бол 2024 оны 03-р сарын 15-ны өдрөөс эхлэн Х.Тэгшээ нь Гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна. Иймд Та бүхэн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа энэхүү танилцуулга дах Гүйцэтгэх захирлын мэдээлэлд өөрчлөлт орсныг анхаарна уу.

Х.Тэгшээ нь Үнэт цаас гаргагч “Эм Жи Эл Аква” ХХК-ийн 100 хувийн хувьцаа эзэмшигч бөгөөд Үнэт цаас гаргагчийн толгой компани “Ти Эм Эл Трейд” ХХК-ийн 100 хувийн хувьцаа эзэмшигч юм.

Иймд, тус шийдвэр нь Үнэт цаас гаргагчийн хувьцааг анх удаа нийтэд санал болгох (IPO) үйл ажиллагаанд харшлах аливаа ашиг сонирхлын болон хууль эрх зүйн зөрчилгүй бөгөөд Үнэт цаасны танилцуулгын хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй болохыг мэдэгдэж байна.

### Гүйцэтгэх захирлын танилцуулга



Хархүү  
**Тэгшээ**

Гүйцэтгэх захирал

#### Ажлын туршлага:

- 2024 оноос** “Эм Жи Эл Аква” ХХК, Гүйцэтгэх захирал
- 2024 оноос** “ТЖТБ” ХХК, ТУЗ-ийн гишүүн
- 2023 оноос** “Эс И Эс Эл Смарт Солюшн” ХХК, Ерөнхий захирал
- 2022 оноос** “Эс И Жи Вай Вай” ХХК, Гүйцэтгэх захирал
- 2021-2023** “ТЖТБ” ХХК, Гүйцэтгэх захирал
- 2021 оноос** “Ти Эм Эл Констракшн” ХХК, Гүйцэтгэх захирал
- 2021 оноос** “Шидэт Чандмань Эрдэнэ” ХХК, Гүйцэтгэх захирал
- 2018 оноос** “Нью Шилэн Интернэйшнл” ХХК, Гүйцэтгэх захирал
- 2017 оноос** “Ньюгор” ХХК, Ерөнхий захирал
- 2017 оноос** “Эм Пластик” ХХК, Ерөнхий захирал
- 2014 оноос** “Ти Эм Эл Трейд” ХХК, Ерөнхий захирал
- 2006 оноос** “Ти Эм Эл” ГХОХХК, Ерөнхий захирал

#### Боловсрол:

- 1999-2003** БНХАУ, Өвөр Монголын Их Сургууль /Inner Mongolia University/, Химич (Бакалавр)

## НЭГТГЭСЭН ОРЛОГЫН ТАЙЛАН

### Үнэт цаас гаргагчийн орлогын тайлан , сая төгрөг

2018-2023.06.30-нарх гүйцэтгэл, 2023-2028 оны төсөөлөл

	2018	2019	2020	2021	2022	2023Н1	2023Т	2024Т	2025Т	2026Т	2027Т	2028Т
	Аудитлагдсан						Төсөөлөл					
Борлуулалтын орлого	6,621	9,541	8,302	20,895	33,351	9,754	23,110	34,224	50,636	62,852	76,664	91,633
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	4,347	6,149	5,541	12,484	20,332	5,115	11,263	15,535	22,626	27,739	33,776	40,311
Нийт ашиг (алдагдал)	2,274	3,393	2,761	8,411	13,020	4,640	11,847	18,689	28,010	35,113	42,888	51,322
Хүүгийн орлого	-	5	4	-	-	0	-	-	-	-	-	-
Бусад орлого	12	4	115	31	-	-	-	-	-	-	-	-
Борлуулалт маркетингийн зардал	6	44	20	38	18	331	869	4,997	6,260	7,483	8,332	9,052
Ерөнхий удирдлагын зардал	1,593	2,008	1,938	2,460	7,229	1,807	4,384	4,074	5,046	5,550	5,812	6,316
Санхүүгийн зардал	-	-	-	209	274	542	1,186	1,219	1,388	1,008	728	485
Бусад зардал	35	105	34	112	59	377	568	101	170	154	178	209
Бусад олз (гарз)	0	24	257	(12)	422	(174)	(0)	-	-	-	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг	653	1,269	1,144	5,612	5,862	1,409	4,840	8,298	15,146	20,918	27,838	35,259
Орлогын татварын зардал	67	132	92	548	599	196	514	1,286	2,421	3,637	5,058	6,646
Татварын дараах цэвэр ашиг	586	1,137	1,052	5,064	5,263	1,213	4,327	7,012	12,725	17,281	22,780	28,614

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын тайлан, сая төгрөг

2018-2023.06.30-нарх гүйцэтгэл, 2023-2028 оны төсөөлөл

	2018	2019	2020	2021	2022	2023Н1	2023Т	2024Т	2025Т	2026Т	2027Т	2028Т
	Аудитлагдсан						Төсөөлөл					
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>3,655</b>	<b>6,587</b>	<b>13,832</b>	<b>21,486</b>	<b>23,945</b>	<b>18,229</b>	<b>19,881</b>	<b>26,675</b>	<b>40,074</b>	<b>54,146</b>	<b>78,652</b>	<b>111,244</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	43	27	98	21	42	296	1,678	10,036	20,718	29,734	49,066	74,990
Дансны авлага	2,320	5,489	670	875	1,040	2,227	4,051	4,615	7,012	9,207	10,310	15,616
Татвар, НДШ-ийн авлага	19	-	47	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад авлага	88	88	3,607	5,685	9,471	3,515	3,658	3,884	4,926	5,379	5,530	6,284
Бараа материал	1,186	982	2,923	1,307	2,166	3,313	3,603	4,881	6,948	7,208	10,025	10,048
Урьдчилж төлсөн зардал	-	1	6,487	13,598	11,226	8,878	6,890	3,258	1,011	2,618	3,721	4,307
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>1,465</b>	<b>977</b>	<b>1,081</b>	<b>1,441</b>	<b>4,000</b>	<b>17,736</b>	<b>16,843</b>	<b>28,113</b>	<b>29,552</b>	<b>32,507</b>	<b>31,122</b>	<b>29,673</b>
Үндсэн хөрөнгө	1,005	969	1,074	1,435	2,908	16,557	15,668	26,945	28,392	27,055	25,678	24,237
Биет бус хөрөнгө	10	9	7	6	5	1,179	1,176	1,168	1,160	1,152	1,144	1,136
Урт хугацаат хөрөнгө оруулалт	450	-	-	-	-	-	-	-	-	4,300	4,300	4,300
Дуусаагүй барилга	-	-	-	-	1,087	-	-	-	-	-	-	-
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>5,120</b>	<b>7,564</b>	<b>14,913</b>	<b>22,927</b>	<b>27,945</b>	<b>35,965</b>	<b>36,724</b>	<b>54,788</b>	<b>69,626</b>	<b>86,653</b>	<b>109,774</b>	<b>140,917</b>
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>5,026</b>	<b>6,333</b>	<b>12,750</b>	<b>14,949</b>	<b>15,455</b>	<b>15,013</b>	<b>12,713</b>	<b>7,332</b>	<b>8,703</b>	<b>10,309</b>	<b>11,571</b>	<b>14,100</b>
Дансны өглөг	4,993	6,155	7,216	7,853	5,981	1,462	1,996	2,008	3,392	4,294	5,282	6,857
Цалингийн өглөг	1	-	120	1,216	-	241	-	-	-	-	-	-
Татварын өр	18	139	63	242	1,530	1,888	938	503	1,378	1,575	2,260	3,059
НДШ-ийн өглөг	-	19	-	-	148	146	-	-	-	-	-	-
Богино хугацаат зээл	-	-	-	1,950	1,379	7,877	7,000	2,461	1,526	1,859	921	110
Урьдчилж орсон орлого	0	9	7	8	37	35	38	-	-	-	-	-
Бусад богино хугацаат өр төлбөр	13	11	5,345	3,680	6,381	3,363	2,742	2,360	2,406	2,580	3,107	4,073
<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>120</b>	<b>120</b>	<b>-</b>	<b>750</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2,039</b>	<b>2,781</b>	<b>921</b>	<b>-</b>	<b>-</b>
Урт хугацаат зээл	120	120	-	750	-	-	-	2,039	2,781	921	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>5,146</b>	<b>6,453</b>	<b>12,750</b>	<b>15,699</b>	<b>15,455</b>	<b>15,013</b>	<b>12,713</b>	<b>9,371</b>	<b>11,484</b>	<b>11,230</b>	<b>11,571</b>	<b>14,100</b>
Хувьцаат капитал	574	574	574	574	574	600	600	819	819	819	819	819
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-	-	7,246	7,246	7,246	7,246	7,246	7,246	7,246
Нэмэгдэж төлөгдсөн капитал	-	-	-	-	-	-	-	14,175	14,175	14,175	14,175	14,175
Хуримтлагдсан ашиг	(599)	538	1,590	6,654	11,917	13,107	16,165	23,177	35,902	53,183	75,963	104,577
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>(26)</b>	<b>1,111</b>	<b>2,163</b>	<b>7,228</b>	<b>12,490</b>	<b>20,953</b>	<b>24,011</b>	<b>45,417</b>	<b>58,142</b>	<b>75,423</b>	<b>98,203</b>	<b>126,817</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>5,120</b>	<b>7,564</b>	<b>14,913</b>	<b>22,927</b>	<b>27,945</b>	<b>35,965</b>	<b>36,724</b>	<b>54,788</b>	<b>69,626</b>	<b>86,653</b>	<b>109,774</b>	<b>140,917</b>



# НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

## Үнэт цаас гаргагчийн мөнгөн урсгалын төсөөлөл, сая төгрөг

2018-2023.06.30-нарх гүйцэтгэл, 2023-2028 оны төсөөлөл

	2023T	2024T	2025T	2026T	2027T	2028T
<b>Үйл ажиллагааны мөнгөн урсгал</b>						
<b>Үйл ажиллагааны орох мөнгөн урсгал</b>	<b>24,948</b>	<b>37,309</b>	<b>55,186</b>	<b>66,418</b>	<b>81,010</b>	<b>96,826</b>
Бэлэн бараа материал борлуулснаас орох	24,913	37,270	55,142	66,371	80,957	96,764
Бусад үйл ажиллагаанаас орох	35	39	44	46	53	62
<b>Үйл ажиллагааны гарах мөнгөн урсгал</b>	<b>(21,593)</b>	<b>(25,853)</b>	<b>(43,175)</b>	<b>(49,535)</b>	<b>(58,109)</b>	<b>(72,726)</b>
Ажилтанд төлсөн	(4,166)	(6,085)	(7,784)	(8,881)	(9,667)	(10,562)
Нийгмийн даатгалд төлсөн	(532)	(817)	(1,040)	(1,184)	(1,289)	(1,409)
Түүхий эд материал худалдан авахад төлсөн	(10,780)	(11,700)	(23,039)	(27,594)	(34,200)	(39,080)
Ашиглалтад төлсөн	(72)	(63)	(77)	(86)	(91)	(96)
Шатахуун, тээврийн хэрэгсэлд төлсөн	(490)	(984)	(1,434)	(1,862)	(2,228)	(2,461)
Хүүгийн зардалд төлсөн	(1,186)	(1,219)	(1,388)	(1,008)	(728)	(485)
НӨАТ-т төлсөн	(974)	(1,081)	(2,013)	(2,393)	(3,243)	(3,980)
Татварын байгууллагад төлсөн	(795)	(630)	(900)	(1,854)	(3,029)	(4,347)
Даатгалд төлсөн	(37)	(54)	(69)	(74)	(70)	(70)
Бусад үйл ажиллагааны зардалд төлсөн	(2,560)	(3,220)	(2,655)	(4,600)	(3,563)	(5,681)
<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн урсгал</b>	<b>3,355</b>	<b>11,455</b>	<b>14,787</b>	<b>16,883</b>	<b>22,901</b>	<b>28,655</b>

<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн урсгал</b>						
Үндсэн хөрөнгө худалдан авалт зарцуулсан	(842)	(14,990)	(4,453)	(1,500)	(1,710)	(1,810)
Хөрөнгө оруулалт	-	-	-	(4,300)	-	-
<b>Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн урсгал</b>	<b>(842)</b>	<b>(14,990)</b>	<b>(4,453)</b>	<b>(5,800)</b>	<b>(1,710)</b>	<b>(1,810)</b>

<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал</b>						
Энгийн хувьцаа гаргаснаас орсон	-	14,394	-	-	-	-
Зээл, өрийн үнэт цаас гаргаснаас орсон	-	2,500	3,000	-	-	-
Зээл, өрийн үнэт цаас эргэн төлсөн	(877)	(5,000)	(3,193)	(1,526)	(1,859)	(921)
<b>Санхүүгийн цэвэр мөнгөн урсгал</b>	<b>(877)</b>	<b>11,894</b>	<b>(193)</b>	<b>(1,526)</b>	<b>(1,859)</b>	<b>(921)</b>
<b>Цэвэр мөнгөн урсгал</b>	<b>1,636</b>	<b>8,359</b>	<b>10,141</b>	<b>9,556</b>	<b>19,332</b>	<b>25,924</b>
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	42	1,678	10,036	20,178	29,734	49,066
<b>Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,678</b>	<b>10,036</b>	<b>20,178</b>	<b>29,734</b>	<b>49,066</b>	<b>74,990</b>

“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХХК

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

ҮЗҮҮЛЭЛТ	(төгрөгөөр)	
	2020	2021
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Тайлант жилийн ашиг (алдагдал)</b>	<b>1,052,293,583</b>	<b>5,064,109,971</b>
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	76,709,492	109,836,511
Валютын ханшийн бодит бус цэвэр гарз/(олз)	(257,833,741)	7,462,943
Авлагын өсөлт, бууралт	(5,171,149,215)	(2,283,015,991)
Урьдчилж төлсөн зардал/тооцооны бууралт (өсөлт)	(15,350,704)	(7,110,915,933)
Бараа материалын өсөлт, бууралт	(1,941,039,722)	1,616,640,226
Богино хугацаат өр төлбөрийн өсөлт, (бууралт)	6,292,028,913.59	(139,442,255)
Орлогын албан татварын зардал	91,763,722.97	547,783,185
Төлсөн орлогын албан татвар	(87,014,685.87)	(158,811,278)
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>40,407,643</b>	<b>(2,346,352,619)</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын худалдан авалт	(5,000,000)	(430,399,363)
Хүлээн авсан хүүний орлого	154,747	
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(4,845,253)</b>	<b>(430,399,363)</b>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
Хүлээн авсан зээл болон өр төлбөр	35,285,294	3,000,000,000
Зээл болон өр төлбөрийн эргэн төлөлт		(300,000,000)
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>35,285,294</b>	<b>2,700,000,000</b>
<b>БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>70,847,684</b>	<b>(76,751,982)</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	27,153,086	98,000,770
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	98,000,770	21,248,787

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХХК

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

ҮЗҮҮЛЭЛТ	(төгрөгөөр)	
	2021	2022
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Тайлант жилийн ашиг (алдагдал)</b>	<b>5,064,109,971</b>	<b>5,262,667,067</b>
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	109,836,511	229,674,577
Валютын ханшийн бодит бус цэвэр гарз/(олз)	7,462,943	-
Авлагын өсөлт, бууралт	(2,283,015,991)	(4,179,210,074)
Урьдчилж төлсөн зардал/тооцооны бууралт (өсөлт)	(7,110,915,933)	1,845,167,686
Бараа материалын өсөлт, бууралт	1,616,640,226	(859,836,070)
Богино хугацаат өр төлбөрийн өсөлт, (бууралт)	(139,442,255)	575,052,326
Орлогын албан татварын зардал	547,783,185	599,000,404
Төлсөн орлогын албан татвар	(158,811,278)	(429,216,598)
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(2,346,352,619)</b>	<b>3,043,299,319</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын худалдан авалт	(430,399,363)	(1,724,644,200)
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(430,399,363)</b>	<b>(1,724,644,200)</b>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
Хүлээн авсан зээл болон өр төлбөр	3,000,000,000	633,870,725
Зээл болон өр төлбөрийн эргэн төлөлт	(300,000,000)	(1,954,924,333)
Валютын ханшийн зөрүү		23,060,232
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>2,700,000,000</b>	<b>(1,297,993,376)</b>
<b>БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(76,751,982)</b>	<b>20,661,743</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	98,000,770	21,248,787
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	21,248,787	41,910,530

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХХК

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2023 ОНЫ 6 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

ҮЗҮҮЛЭЛТ	(төгрөгөөр)		
	2022 – I хагас	2022 – II хагас	2023 – I хагас
<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
<b>Тайлант жилийн ашиг (алдагдал)</b>	<b>2,881,183,099.76</b>	2,381,483,967.18	<b>1,162,857,800.00</b>
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	76,303,961.42	153,370,615.72	233,252,352.36
Валютын ханшийн бодит бус цэвэр гарз/(олз)			(182,893.54)
Үндсэн хөрөнгө борлуулсаны гарз (олз)			
Бусад мөнгөн бус орлого			
Авлагын өсөлт, бууралт			
Урьдчилж төлсөн зардал/тооцооны бууралт (өсөлт)	(1,532,355,032.28)	(2,419,662,136.00)	4,768,875,986.07
Дуусаагүй үйлдвэрлэлийн өсөлт	(1,866,787,257.78)	4,239,595,100.00	2,347,812,157.00
Бараа материалын өсөлт, бууралт	(132,484,243.98)	(727,351,826.31)	(1,146,278,212.11)
Богино хугацаат өр төлбөрийн өсөлт, (бууралт)	1,629,478,816.00	(1,850,583,036.22)	(7,117,191,992.25)
Орлогын албан татварын зардал	324,998,612.49	274,001,791.73	196,112,062.63
Төлсөн орлогын албан татвар	(165,000,000.00)	(264,216,597.88)	(20,000,000.00)
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>1,215,337,955.63</b>	<b>1,786,637,878.22</b>	<b>425,257,260.16</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын борлуулалт			
Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын худалдан авалт	(541,608,788.66)	(1,183,035,411.35)	(206,515,900.00)
Хүлээн авсан хүүний орлого			265,395.94
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(541,608,788.66)</b>	<b>(1,183,035,411.35)</b>	<b>(206,250,504.06)</b>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
Хүлээн авсан зээл болон өр төлбөр		633,870,725.00	7,613,348,375.50
Зээл болон өр төлбөрийн эргэн төлөлт	(900,000,000.00)	(1,054,924,333.02)	(7,577,858,980.00)
Валютын ханшийн зөрүү		23,060,231.59	
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(900,000,000.00)</b>	<b>(397,993,376.43)</b>	<b>35,489,395.50</b>
<b>БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(226,270,833.02)</b>	<b>205,609,090.45</b>	<b>254,496,151.60</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	21,248,787.17	247,519,620.19	41,910,529.74
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	247,519,620.19	41,910,529.74	296,406,681.34

Хаасаргаасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.